



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/618

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2, Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цаашдын үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор 7 дугаар сарын 7-ны өдөр айлчилсан Швейцарийн холбооны улсаас Бээжин хотод суух элчин сайд Жийн Жакюзэ дэ Дарделыг хүлээн авсан зардлыг 361900 /Гурван зуун жаран нэгэн мянга есөн зуу/ төгрөг, 7 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд айлчилсан БНХАУ-аас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Шин Хаймин тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авсан зардлыг 1350730 /Нэг сая гурван зуун тавин мянга долоон зуун гуч/ төгрөг, 8 дугаар сарын 8-ны өдөр айлчилсан ХБНГУ-ын Бонн, Барут Марк хотын төлөөлөгчдийг хүлээн авсан зардлыг 239340 /Хоёр зуун гучин есөн мянга гурван зуун дөч/ төгрөг, 8 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд айлчилсан БНСУ-ын Намянжү хотын дарга И СогҮ тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авсан зардлыг 1227650 /Нэг сая хоёр зуун хорин долоон мянга зургаан зуун тавь / төгрөгөөр тус тус тооцож зарцуулсугай.

2. Дээрх зардлыг "Засаг дарга" данснаас гаргаж зарцуулахыг аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч /Ц.Мөнхтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л. ГАНБОЛД